



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР
ТАНИЛЦУУЛГА**

321 дүгээр байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70444469
Цахим шуудан: Sankhuuaudit.bkh.gov.mn
Цахим хаяг: www.sankhuu.bkh.gov.mn

2025.06.16 № 08/31

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.БЯМБАДОРЖ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА М.ЖАВЗАНСҮРЭН НАРТ

Засаг даргын Тамгын газрын 2023, 2024
оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт,
зарцуулалтад хяналт шалгалт
хийсэн тухай

1. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх", 8.2.3 дахь "сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг тус тус үндэслэн хяналт шалгалтыг явууллаа.

2. Шалгалтын зорилго.

Хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдал, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, үр өгөөжийг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, ажил хариуцсан албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн

туслах арга хэрэгсэл шалгалтын үндэслэл

642508066

бодох бүртгэл хөтлөх”, 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх” 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”, 20.1.1-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-т “Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан, уг улсын байцаагчийг томилох эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ”, 10.9.11-т “улсын байцаагч хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах”, Монгол Улсын Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Баян-Овоо сумын иргэн, оюунтан суралцагчид нарт 2022 оноос 2024 онуудын хооронд олгосон сургалтын тэтгэмж, тэтгэлэг хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл, оюунтантай байгуулсан гэрээ, анхан шатны баримт, төлбөр төлсөн баримтыг шаардсан хугацаанд ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг дарга Т.Бямбадорж, Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Б.Наранцэцэг, Санхүүгийн албаны дарга Д.Отгонцэцэг, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн Д.Эрдэнэбулган, Нягтлан бодогч Л.Алимаа нарт хариуцуулав.

2. Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.

3. Хяналт шалгалтаар өгсөн албан шаардлагыг биелүүлж, шаардсан хугацаанд баримт материалыг ирүүлж ажиллахыг Баян-Овоо сумын Засаг дарга Т.Бямбадорж, Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Б.Наранцэцэг, Санхүүгийн албаны дарга Д.Отгонцэцэг, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн Д.Эрдэнэбулган, Нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав.

4. Албан шаардлагыг биелүүлээгүй, хариуг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд "Дотоод аудитын дүрэм"-ын дагуу хариуцлага тооцож ажиллахыг анхааруулж байна.

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАВРАГТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААТЧ   Б.БАТ-ЭРДЭНЭ

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА   Т.БЯМБАДОРЖ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.НАРАНЦЭЦЭГ
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА  Д.ОТГОНЦЭЦЭГ
ТӨСӨВ ТӨРИЙН САНГИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЭРДЭНЭБУЛГАН
НЯГТЛАН БОДОГЧ  Л.АЛИМАА